

(3) sngags ...rtags can gyi brgyud ni/ mdzad pa po ni/ sngags rams pa Ngag-dbang-tse-dpag/ rje slob dpon rin po che Tse-ring-dkon (mchog) rDo-rje-dpal-bzang-po/ des bdag la'o//

1. Шинжлэх Ухаан Амьдрал (сэтгүүл) УБ., 1985, № 1, 57-59-р тал
2. gombojab.S, Monvolcud töbed kele-ber jokiyavsan jokiyalun juyil, - Tom. 1., Fasc, 28. , UB. 1961.
3. Монголын судлал. Том. VII/15/, Fasc,2,, 1982., 48-р
4. Р. Бямбаа «Лувсандаш төвд хэл бичгийн шинжлэлтэн болох нь ШИНЖЛЭХ УХААН ЗАЛУУЧУУД (өгүүллийн эмхтгэл) УБ., 1987
5. Төвд эх Дэргэ Данжуур 217-р боть., 92—98-р тал Монгол эх Монгол Данжуур, 197-р боть, 1—10-р тал
6. Мөн тэнд, 197-р боть, 10—125-р тал.
7. Р. Бямбаа, «Праманасамуччая»-гийн төвд тайлбарт хийсэн Дандар аграмбагийн ариутгал», Дорнодахны судлалын асуудал (сэтгүүл) УБ., 1987, 65-р тал.

**СИНЬЦЗЯН — УЙГАРЫН АВТОНОМИТ  
РАОЙН ДАХЬ ХЯТАД БИШ АРД ТҮМНИЙ  
СОЁЛЫН ӨВ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

**М. Хурметхан  
Ч. Батцэцэг**

Социалист соёлын бүтээн байгуулалтад эртний соёлын өв уламжлал чухал байр эзэлдэг юм. В. И. Ленин соёлын өвийг социалист нийгмийн маш чухал «бүтээн байгуулах материалын» нэгэн хэсэг хэмээн үзэж байв. В. И. Ленин хүн төрөлхтний өмнөх эд өлгийн болон оюун санаанд хүрсэн тэр үнэ цэнэтэй, дэвшилттэй зүйлийг социалист нийгэмд эзэмшиж, амьдрал практикт ашиглах нь онцгой чухал ач холбогдолтой гэж заасан билээ. В. И. Ленин бичихдээ: «Хөрөнгөтний болон капитализмын соёлыг бий болгосон соёл, техник, арга хэрэгслийг авч хэрэглэхгүйгээр социализмыг байгуулашгүй юм»<sup>1</sup> гээд «Капитализмын соёлоос авч, социализмыг бүтээн байгуулахад хэрэглэх хэрэгтэй. Ингэхгүйгээр бид коммунист нийгмийн амьдралыг байгуулж чадахгүй»<sup>2</sup> гэжээ. В. И. Ленин бүх соёлын тухай ярихдаа хуучин нийг мийн хаях ёстой зүйл, устгаж арилгавал зохих зүйлийг, хадгалж үлдэх зүйлээс ялган үзэж байв.

БНХАУ байгуулагдсаны дараа тус оронд үндэстний соёлын өвд нааштай хандах, соёлын өвийг цуглуулах, судлах, хамгаалах талаар нэлээд ажил хийж эхлэв. ХКН-аас БНХАУ байгуулагдсаны дараа хятад биш бусад үндэстний нэг адил Синьцзян-Уйгарын автономит

районы хятад биш ард түмний соёлын өвийг хамгаалах, судлах ажил хийж байв. Гэтэл Хятадад 50-иад оны сүүлчээс явуулсан удаа дараагийн улс төрийн хөдөлгөөн, «соёлын хувьсгалын» жилүүдэд хятадад үндэстний соёлын өвд хандах хандлага эрс өөрчлөгдөн үндэстний соёлын илрэл болгоныг хүчээр устгах явуулга хийсэн билээ. 1978 оноос үндэстний соёлын өвийн асуудалд тодорхой өөрчлөлт гарч БНХАУ байгуулагдсаны дараах эхний арван жилийн адил соёлын өвийг цуглуулах, судлах ажил явуулж «соёлын хувьсгалын» үед үндэстний соёлын өвийг их хэмжээгээр сүйтгэснийг шүүмжилж байна.

«Соёлын хувьсгалын» жилүүдэд Синьцзян дахь Хятад биш ард түмний соёлын өв их хохирол үзсэн хэдий боловч олон мянган жилийн турш хөгжүүлж ирсэн соёлынхоо өвийн тодорхой хэсгийг хамгаалан үлдсэн юм. Хятадын «соёлын хувьсгал»-ын алдаа завхрал ч соёлын хөгжил дэх залгамжлах чанарыг алдагдуулж чадсангүй. Соёлын уламжлагдах чанарын тухай В. И. Ленин бичихдээ «Соёлыг яаж ч эвдэж сүйтгэлээ гэсэн түүнийг түүхт амьдралаас арилгачихаж болохгүй, түүнийг сэргээхэд хэцүү боловч ямар ч эвдрэл сүйтгэл хэзээ ч соёлыг ор мөргүй алга болгочихгүй. Соёл бол устаж арилшгүй бөгөөд өөрийн аль нэг салаа мөчир, аливаа нэг эд агуурсын зүйлст хадгалагдаж үлддэг юм. Гагцхүү түүнийг сэргээх нь бэрхшээлтэй байдаг»<sup>3</sup> гэсэн билээ. 1966—1976 онуудад Синьцзян дахь Хятад биш ард түмний соёл нь ихээхэн эвдрэн сүйдсэн хэдий боловч соёлын хувьсгалынхан түүнийг бүрмөсөн устгаж чадаагүй. Сүүлийн хэдэн жилд тус районд соёлын өвд хандах хандлагад өөрчлөлт гарч, соёлын устсан буюу ховор дурсгалыг дахин сэргээх цуглуулах, судлах ажил хийх явцад соёлын дурсгалууд олдож байгаа зэргээс харагдаж байна.

Дорнод Туркестан дахь хятад биш ард түмний баялаг соёлын тухайд XVI зуунд казахын алдарт эрдэмтэн Чокан Валиханов бичихдээ «Европт нүүдэлчин аймгуудыг зөвхөн зэрлэг бүдүүлэг амьтас мэтээр төсөөлөн ухаардаг нь одоо хир ноёрхсоор байна. Нүүдэлчин монголчууд, казахуудын тухай ойлголт нь бүдүүлэг, мал шиг зэрлэг гэсэн үзэл бодолтой нягт холбоотой. Гэтэл эдгээр зэрлэгүүдийн ихэнх хэсэг нь өөрийн уран зохиол, бичгийн болон аман үлгэр туульстай байв» гэжээ. Дорнод Туркестаны ард түмний биеэ даасан соёл нь бусад ард түмний соёлд нөлөөлж байсан нь тодорхой. Тухайлбал, «Дорнод Туркестаны соёл түүний дотор шашинд түүхэн нөхцөл газарзүйн байдлаас Энэтхэг болон Дундад Ази, Хятад нөлөөлжээ. Соёлын урсгал Хятадын зүгээс сул байсан ч гэсэн Кашгарын орон нутгийн ард түмний эд өлгийн болон оюуны соёлын амьдралд мөрөө үлдээсэн байна.»<sup>5</sup>

Дорнод Туркестаны ард түмний соёл нь гарал үүсэл хийгээд түүхийн хувьд Казахстан, Дундад Азийн соёлын нөлөөнд байжээ. «Эрт дээр үеэс шинэ үе хүртэл Дорнод Туркестаны түүхийн голлох зүйл нь Дундад Азитай угсаатны соёл түүхийн уялдаатай байв. Эрт дээр үе болон дундад зуун бүрэлдэн тогтоход Дундад Ази-Дорнод Туркестаны угсаатны соёлын бүс нутаг байжээ»<sup>6</sup> гэсэн зөвлөлтийн эрдэмтдийн үнэлэлт дүгнэлт үнэн зөв гэдгийг тэмдэглэн, санал нэгтэй байна.

Хятадын соёлын нөлөөний хувьд дараах зүйлийг тэмдэглэж болох юм. «Энэ нь хувцас хунар, буу зэвсэг, толь, нэхмэл эдлэл болон бусад зүйлд хамаарна. Худалдаа наймааны үр дүнд олон зүйл гарч

иржээ. Хятадуудаас зарим нэгэн юм дэлгэрч мөн тэндээс зээлдэн авчээ.<sup>7</sup>

Синьцзян дахь хятад биш үндэстнүүд түүхийнхээ туршид эд өлгийн болон оюуны соёлын асар их дурсгалыг туурвин бүтээсэн юм. Эдгээр ард түмний соёлын өв нь бүр эртнээс эхтэй билээ.

Эртний уйгар хэлний бичиг үсэг олон янзын бичгийн цагаан толгойд үндэслэгджээ. Үүнд руни бичиг (Сэлэнгийн чулуу VI—IX зуун, суджийн дурсгал 840—762 он), карабал-расийн бичээс vШ-IX зуун (Турфаны бичээс), энэтхэгийн-брахми (бурхан шашны агуулгатай сэдэв), манихейн бичээс (манихей нарын гэмшлийн мөргөл), манихей захидлын дурсгал V—VII зуун), сирийн (христосын несторианы шашны агуулгатай, сири хэл дээр бичсэн захидал) согдийн (буддын-гүн ухааны агуулгатай сэдэв, тухайлбал, «Алтан гэрэл» судар, V—IX зуунд хамаарах хууль эрхийн бичиг баримтууд болон эцэст нь араб бичиг орно.

IX-X зуунд Уйгарын хийж бүтээсэн соёлын өв дурсгалаас Ленинград, Берлин, Парис, Лондон болон өөр зарим нэгэн газарт цөөнгүй хадгалагдаж байгаа бөгөөд тэдгээр өвийг урьд нь судалсан боловч цаашид мөн судлах шаардагатай хэвээр байна. Туркийн эрдэмтэн профессор Р. Аратын тооцоолсноор уйгарын бичгийн дурсгалын өвийг харьцуулахад судлагдсан хэсэг нь нэг хувь, үлдсэн 99 хувь нь судлагдаагүй хэвээр байгаа ажээ.

Олон эрдэмтдийн судалгааны үр дүнд X зуунаас өмнөх эртний уйгарын уран зохиолчдын бүтээлтэй танилцах боломжтой болсон билээ. Манихей ба буддын шашны талаархи Ботурмиш, Тархан, Апринчур, Текин, Кол Таркан, Сингу, Сели, Калиман Кайши, Кики мэтийн хүмүүсийн бүтээл, орчуулга нь Зөвлөлт Холбоот Улс болоод бусад орнуудад нийтлэгдсэн юм. Уйгар болон Синьцзян дахь хятад биш ард түмэн өөрийнхөө түүхийн явцад аман зохиолын болон бичгийн зохиолын баялаг санг бүтээжээ. «Дорнод Туркестанд бичгийн, аман гэсэн хоёр төрлийн зохиол байна. Уран зохиолын бичгийн дурсгалууд гол төлөв орчуулгаас бүрджээ. Араб, перс, хятад хэлнээс орчуулагдсан хэдий ч ардын уран зохиол баялаг юм»<sup>8</sup> гэж Дорнод Туркестаныг судлагч Н. Катанов тэмдэглэжээ.

Дорнод Туркестаны хятад биш ард түмний сонгодог бичгийн уран зохиол бүрэлдэх явцад уран зохиол, шашны ном зохиолын орчуулгын урлаг хөгжив. Уйгарын соёлд буддын шашны агуулгатай судруудыг түрэг хэлэнд орчуулснаар эхэлжээ. Эдгээрийн дунд шашин шүтлэгийн зохиол болох «Алтан ярук» («Алтан гэрэл»)-ийг уйгар хэлнээ орчуулсан нь сонирхолтой юм. Уйгар үсгээр бичсэн «Алтан ярук»-ийн гар бичмэлийг С. Е. Малов 1910 онд Буншингу (Ганьсу) хэмээх буддын нэгэн сүмээс олжээ. С. Е. Малов, В. В. Радлов нар хожим энэ зохиолыг хэвлүүлсэн ажээ. Энэхүү судрыг Сынгку Сели Тудунгам X зуунд уйгар хэлнээ орчуулжээ. «Алтан ярук» нь шашны агуулгатай бөгөөд эх бичиг биш, орчуулгын зохиол учир агуулгын хувьд төдий л сонирхолтой биш гэж эрдэмтэд үздэг. Гэвч тэр нь эртний уйгар хэл уйгар бичиг болон лалын шашин дэлгэрэхээс өмнө буддын шашныг шүтэж байсан уйгарын соёл, утга зохиолын чухал дурсгал гэж тооцогддог.

Түрэг хэлтэн ард түмний бичиж үлдээсэн IV зууны томоохон дурсгалт бичгийн нэг нь «Огузнаме» юм. Бээжин дэх Үндэстний төв институтын Түрэг хэлний факультетын казах хэлний салбарын эрхлэгч Гэн Шимлин, түүний орлогч Макен Какенулы Иликенов нар 1986 онд казах хэлэнд орчуулж Бээжин хотод хэвлүүлжээ.

Түрэг хэлтэн ард түмний түүх, уран зохиолын оргил нь болсон Юсуф Хас-Хаджиб Баласагунийн зохиосон түрэг хэлтэн ард түмний гайхамшигт дурсгал бол «Хутагт билиг» гэдэг алдарт зохиол мөн. Энэхүү зохиолыг 1069 онд Кашгар хотод бичиж дуусгажээ. «Хутагт билиг» 82 бүлэг 13000 мөр бүхий яруу найргийн зохиол юм. Уг зохиолын уйгар үсгээр бичсэн эх нь Вена болон Герат, араб үсгээр бичсэн нь Каирт, Наманганы эх нь бидэнд уламжлагдан ирсэн хийгээд дэлхийн олон орны эрдэмтэд тал бүрээс судалсаар иржээ. Уг зохиолыг турк, казах, узбек, уйгар, хэлээр гаргасан. Мөн орос, англи хэлэнд орчуулан гаргасан «Хутагт билиг»-ийг хятад хэлэнд орчуулж, 1987 онд Бээжинд хэвлэсэн байна.

Уйгарын ард түмний сонгодог уран зохиолын цаашдын хөгжилд эртний уйгар хэл-чагаадай хэл мөн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Эртний уйгарын утга зохиолын хэл дэлгэрэн түгсэн төв нь Кашгар хот, түүний ойр орчмын хот суурин газар байв. Энэхүү хэлээр уйгарын уран зохиолын сонгодог зохиолчид Мухамед Имин Киркити («Муха бат наме ва михнаткам»), Залили («Тазкира-и Чалтан»), Новбити («Газеллер»), Абдурами Назири («Раби саадин»), Молла Билал («Китаби газати-дар Мюлки Чин»), Мухаммед Садык Кашгари («Таз кира-и азизан»), Молла Сайрами («Тарихи амания») гэх мэт зохиолууд туурвисан юм. Сүүлийн жилүүдэд СУАР-д Хятад биш ард түмний уран зохиолын дурсгалыг судлах, дахин хэвлэх ажлыг сэргээжээ. Дорнод Туркестаны хуучин хот суурийг судалснаар эрдэмтэд эдгээр ард түмний соёлын талаар ихээхэн материал цуглуулсан байна.

Эртний Алмалык хотын орчим Хорин мазер хэмээх газар XIV зуунд баригдсан Туглук Төмөр хааны бунхан бол Дорнод Туркестаны уугуул ард түмний дүрслэх урлагийн шилдэг дурсгал юм. Синьцзян дахь уугуул ард түмний соёлын түүхэнд «Мянган бурхны агуй» томоохон байр эзэлдэг гайхамшигт дурсгал билээ.

XIX зууны 20-иод оноос XX зууны 80-аад он хүртэл Дорнод Туркестаны түүх бичгийн дурсгалыг эрчимтэй судлах ажилд оросын дорнодахины судлаачдын хамтаар баруун Европ, Хятад, Япон, Энэтхэгийн эрдэмтэд оролцсон юм. Үүний үр дүнд түрэг, перс, араб, төвд, грек-латин, хятад болон бусад хэл дээрх сурвалж бичгүүдийг цуглуулах, орчуулах, тайлбарлах, задлан шинжлэх ажил хийсэн байна.

Дорнод Туркестаны хятад биш ард түмний түүх соёлын судлалд орос, Зөвлөлтийн эрдэмтэд Ч. Валиханов, Г. Вамбери, М. Казембек, В. В. Радлов, В. В. Бартольд, С. Ф. Ольденбург, С. Е. Малов, Е. Э. Бертальс, А. К. Боровков, Н. А. Баскаков, Д. И. Тихонов, Т. Р. Рахимов, М. К. Кутлуков, Р. Тинишеев, Г. Садвакасов, А. А. Валитова зэрэг эрдэмтэн их хувь нэмэр оруулсан юм. Мөн Өрнөд Европын Клапрат, Ле Кок, А. Фон Гобен, Г. Ярринг нарын бүтээлийг ч дурдвал зохино.

1899—1914 онд тус нутагт Германы 4 экспедиц ажилласан хийгээд А. Стейний шинжилгээний анги Дорнод Туркестаны бүх нутгийг хамарсан билээ. Эдгээр судалгааны анги ихээхэн хэмжээний материал

(430 авдар) цуглуулсан байжээ. Германы шинжилгээний анги 1902 онд Синьцзян Турфаны Хар Хочжо гэдэг газар малтлага хийж бичмэл, дармал номын тасархайг олноор нь олж аваачсан юм. Эдгээр хэрэглэгдэхүүний нэлээд хэсгийг Э. Хейнеш «Монголика дер Берлинер Турфан-Заммулуинг» гэсэн хоёр дэвтэр номондоо оруулж, 1954, 1959 онуудад хэвлэн гаргасан байна.

БНХАУ байгуулагдсаны дараа Дорнод Туркестан дахь Хятад биш ард түмний соёлын өвийн асуудалд үндсэндээ зөв байр сууринаас хандаж эхэлжээ. Энэ үед Синьцзяны соёлын өвийг уг районы ард түмний эрх ашигт зориулах чиглэлтэй байв. Энэ үеэс Синьцзяны соёлын өвийг археологи болон бусад салбараар судлах бүлгэм байгуулах бодит ажил хийж эхлэв. Үүний жишээ нь 1953—1957 онуудад Синьцзянд соёлын өвийн талаар хоёр удаа явуулсан том хэмжээний судалгаа юм.

1954 онд эртний хот Кашгарт нэг сарын хугацаатай экспедиц зохион байгуулсан байна. Дараа нь 1955—1956 онуудад уйгарын Урумчи, Кульджа, Кумул хотод экспедиц явуулжээ. 1957 онд Кашгарт дахин экспедиц явуулахын хамтаар Янгисар, Атуш, Яркенд болон бусад газруудад судалгаа хийсэн нь амжилттай болов. Гар бичмэл материал хоёр зуу гаруйг олсны ихэнх хэсэг нь дорно дахины судлалд урьд мэдэгдээгүй зохиолууд буюу урьд тодорхойгүй байсан зохиолууд байв. Үүнээс үзэхэд Дорнод Туркестан нь уйгарын гар бичмэлийн гайхамшигт баялаг дурсгалын сан юм. 1954—1957 оны судалгааны экспедиц Дорнод Туркестаны нутгаас цуглуулсан материалууд хэвлэгдсэн боловч ихэнх нь Урумч хотын эртний гар бичмэлийн музейд хадгалагдан үлджээ. Өөрөөр хэлбэл зарим нэгэн мэдээгээр энэ үед эртний уран зохиолын 948 гар бичмэл, 20 мянган орчим ардын аман зохиолын төрөл зүйлээс цуглуулжээ.<sup>9</sup>

БНХАУ байгуулагдсаны дараах соёлын өвд үндсэндээ зөв байр сууринаас хандах хандлага тодорхой хугацаанд эрс өөрчлөгдөн түүнийг «феодалын хог новш» хэмээн үзэж, устган сөнөөх үзлээр солигдож байсан «соёлын хувьсгалын» үед Синьцзян дахь Хятад биш ард түмний соёл олон зуун жилийн турш тэдний хийж бүтээсэн түүх, соёлын гайхамшигт дурсгалууд их үрэгдсэн юм. Гэвч 70-аад оны сүүлчээс хятадын удирдлагын үндэстний бодлогод тодорхой өөрчлөлт гарсны улмаас соёлын өвд хандах хандлагад ч өөрчлөлт орлоо. Энэ үеэс ард түмний соёлын өвөөс суралцах тухай ярих болж, «соёлын хувьсгалын» жилүүдэд соёлын өвийг устгаж байсны хариуцлагыг «дөрвийн бүлэгт»-т ноогдуулав.

1982 онд хуралдсан ХКН-ын XII их хурал дээр соёлын өвийг хамгаалах тухай ярьжээ. Тухайлбал, БХАТИХ-ын зургаа дахь удаагийн сонгуулийн хоёрдугаар чуулган дээр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд хэлэхдээ: «Соёлын түүхт дурсгалууд болон бусад соёлын үнэт зүйлсийг урьдын адил нандигнан хадгалах хэрэгтэй»<sup>10</sup> гэжээ.

Соёлын өвд хандах ерөнхий чиглэл өөрчлөгдсөнтэй холбогдон 1981 оны 9-р сараас уйгар казахын уламжлалт бичиг үсгийг дахин сэргээн хэрэглүүлэхээр болов. Хятад биш ард түмний эрт, эдүгээгийн түүх, угсаатны зүй, хэл шинжлэл, утга зохиол судлал, Төв Азийн судлал, эдийн засаг, археологийн судлал, шашны хүрээг багтаасан нийгмийн ухааны хүрээлэн Урумчид байгуулагджээ. Өнгөрсөн хуга-

цаанд дээрх хүрээлэн нэлээд хэмжээний зохиол бүтээлээ тус районы хятад биш ард түмний соёлын өвийг судлахад зориулахын хамтаар археологийн зэрэг судалгааны анги ажиллан материал цуглуулж байна. Эртний болон дундад зууны уран зохиолын шилдэг дурсгалыг хэвлэн нийтлэх болов. Тухайлбал, 1983 онд Хятадын «Миньцзу чубаньшэ» хэвлэлийн газар Юсуф Хас Хажиб Баласагуний «Хутагт билиг» зохиолыг орчин үеийн уйгар хэлээр хэвлэсэн юм. Мөн сүүлийн жилүүдэд хятад биш ард түмний соёлын өвд хамаарах 500-700 номыг эмхэтгэж 10 хэлээр 300 гаруй номыг хэвлээд байгаа ажээ. Эдгээр шинээр хэвлэх зохиолын дотор 1400 жилийн өмнө уйгар үсгээр бичигдсэн 27 үзэгдэлт Майдар бурхан уулзсан үлгэр бий ажээ. Улсын онцгой хамгаалалтанд авсан дурсгалт 180 газрыг тоочсон хамгаалалтын дүрэм, тунхагийг хожим 1961 оны 3-р сарын 4-нд нийтлүүлжээ. Одоогийн энэ жагсаалтад: хувьсгалт тэмцлийн холбогдолтой 32 газар, агуйн хийд болон сүм 14, уран барилгын дурсгал 77, баримал хөшөө 11, хот балгасын хана 26, олон янзын хэлбэртэй оршуулгын газар 19 ийг бүртгэжээ. Үүнд: Синьцзяны дараах 4 дурсгалын газар оржээ. Кэцзыр районы төв баруун хэсгийн дурсгал (Байчэн тойрог), Кумутулагийн (Куче тойрог) Мянган бурхны агуй болон Турфаны хотгорын эртний хот Гаочан, Ярхугийн эвдэрхий балгас байна.

1978 онд «Синьцзяны соёлын өв» номыг СУАР-ы музейгээс эрхлэн гаргасан юм. Энэхүү номын оршилд бичихдээ: хуучин хот агуйн болон эртний бунхан зэрэг 115 газрыг автономит районы дархан цаазтай газар болгов.<sup>11</sup> Сүүлийн хэдэн жилд археологийн судлаачид ажилчин, тариачин, цэргүүдтэй хамтран их хэмжээний малтах ажил хийж байна. Эдгээр нь Синьцзяны түүх, соёлын өвийг судлахад чиглэгдэн буй ажээ.

Археологийн судалгаагаар 1961 онд 6 олдвор, 1971 онд 1, 1972 онд 3, 1975 онд 1, 1976 онд 15, 1977 онд 16, 1978 онд 12 археологийн олдвор олдсон байна. Эдгээрийн дотор Астаны булш чухал үнэ цэнэтэй олдвор болсон юм. 1959 оноос 1977 онд археологийн олдвор 400 олноос зөвхөн 260 олдворын тухай л мэдээлжээ.<sup>12</sup> БНХАУ байгуулагдсанаас хойш энэ районд 500 булш малтаж 10 мянга гаруй олдвор олсон байна.

Сүүлийн хэдэн жилээс археологийн дурсгалын тухай тодорхой мэдээлж байна. Тухайлбал, 1986 онд Кашгарын районд эртний түүхийн дурсгал, тосгон, сүм дуган зэрэг 100 гаруй дурсгалын газар байгааг мэдээлэв. 300 боть эртний ном, судар, 600 эд өлгийн зүйл, хувцас, зоос зэргийг илрүүлэн олсон зэрэг мэдээ олонтоо гарч байна.

Синьцзяны байгалийн нөхцөл байдал, хуучныхаа соёлын дэвшилт хэсгийг хадгалан үлдээхийг эрмэлздэг уугуул ард түмний хүчин чармайлтаар энд газрын хөрсөн дээр болон дор буй их хэмжээний соёлын өвийг хадгалж чаджээ. СУАР-ы нутагт явуулсан судалгааны үр дүнд илрүүлсэн археологийн зарим олдворын талаар дор өгүүлье. Эдгээр олдворын ихэнх хэсэгт эртний булш багтах бөгөөд эндээс олдворын 3 мянга гаруй жилийн өмнөх эмэгтэйн булш, 1800-1900 жилийн өмнөх эхнэр нөхрийн цуг оршуулсан булш, 1938 жилийн өмнөх Гаочан хэмээх газрын Жансюнь хэмээх булш зэрэг байв. Эдгээр булшийг Синьцзяны зүүн хэсэгт орших Хами, баруун хэсгийн Вэньсу, Турфан болон Такламаканы их цэлийн дагуух Мэнтэн хошуунаас олжээ. 1988 онд Хамигаас археологийн томоохон дурсгалыг олж илрүүлжээ.

Турфаны булшнаас уйгар үсгээр бичсэн баримт бичгүүд гарчээ. Мөн эртний хотын балгас олдож байна. Түүний дотроос Жулиносэнь сяний Нэяа хэмээх балгас байна. Нэяа гэдэг балгас ширгэсэн голын хоёр эрэг дээр урдаасаа хойшоо 10 км орчим, баруунаас зүүн тийш 2 км талбайтай хот байжээ. Ийм балгаснуудаас археологийн төрөл бүрийн зүйлүүд олдсоор байна.

Үндэсний хувцасны загвар судлах төв, Синьцзяны эрт эдүгээгийн барилга, ард иргэдийн зан заншлын музей, уйгар үндэстний эмнэлэг зэрэг барилга байгууламж байгуулжээ. Хятад биш үндэстнүүд эх хэлээрээ ярилцан, сургуульд эх хэлээр суралцан үндэсний зан заншлын дэвшилт зүйлсийг чөлөөтэй хэрэглэн, өнгөрсөн түүхийн соёлын өвийг судалж байна. Тухайлан энд нэг жишээ дурдахад, Синьцзян дахь казахуудын дунд харилцаа дууны уралдааныг сэргээн, арав гаруй удаа, явуулжээ. Уйгарын ард түмний хөгжмийн дурсгал «Арван хоёр мукамыг» судлах ажил үргэлжилж байна. Эртний болон сонгодог уран зохиолын дурсгалууд дахин уншигчидтайгаа золгов. Жишээлбэл, Киргизийн алдарт туульс «Манас»-ыг Урумчид хэвлэв. Ийм баримт олныг дурьдаж болно,

Уйгар казах болон бусад ард түмний уран барилга гар урлалын дурсгал зэргийг цуглуулан нийтэлж байна. Тухайлбал, СУАР-д хэвлэгдсэн Синьцзяны казахын ардын гар урлалын цомогийг жишээ болгон өгүүлэе. Үүнд Синьцзян, Ганьсу, Цинхай зэрэг газруудаас казахуудын дунд дэлгэрсэн тоорцог, хувцас, эмэгтэй хүний толгойн гоёл, гэр, гутал, эмээл болон төмөр модон эдлэл сав суулганы хээ угалз чимэглэлийг харуулжээ.

«Уйгарын уран барилгын урлагийн үлгэр загвар» /Кашгар 1984/ гэсэн цомогт уйгарын ард түмний уран гараар XV зуунд бүтсэн Туглук Төмөр хааны бунхан зэрэг эртний дурсгалын уламжлалт уран барилгын дагуу Синьцзян Уйгарын автономит районд 1956 онд баригдсан уйгар үндэстний эмнэлгийн барилга зэргийн зургийг оруулжээ. Мөн төрөл бүрийн зориулалт бүхий уран барилгын хээ угалзыг дэлгэн харуулсан байна. Ийнхүү сүүлийн жилүүдэд хятад биш ард түмний соёлд хандах хандлага өөрчлөгдөж байгаа нь тухайн ард түмний соёлыг урагш ахиулахад түлхэц болж байна.

1. В. И. Ленин доклад о работе ВЦИК и Совнаркома на первой Сессии ВЦИК VII созыва 2 февраля, 1910 г., ПСС, 40. С. 102
2. В. И. Ленин. Зохиолууд 27-р боть, 118 дахь тал
3. В. И. Ленин Зохиолууд 27-р боть, 118 дахь тал
4. Валиханов Ч. Соб, соч. т—11 с, 531—533
5. Шефер. Э Золотые персики Самарканда М., 1981., с 15
6. Восточный Туркестан и Средняя Азия: М., 1981, с. 10
7. Мөн тэнд
8. Н. Ф. Катанов. Из Сибири и Восточного Туркестана Приложение к XVIII-му тому записок импер, академии наук. с. 81
9. «Поэты Синьцзяна». Ташкент, 1958 (на узб. языке), с. 5
10. Первая сессия ВСНП КНР шестого созыва главные документы, Бээжин, 1983, с. 57
11. «Синьцзяны соёлыц өв», Бээжин., 1978, с. 3
12. Восточный Туркестан и Средняя Азия., (История, культура, связи) М., 1984, с. 20